



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

Г Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.1.2, 7.1.4. дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад заасан нэр бүхий 4 хуулийн этгээдийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хавсралтад дурдсан нэр бүхий 4 хуулийн этгээдийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад анхааруулсугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны .11 дүгээр сарын 19-ны өдрийн
354 дугаар тогтоолын хавсралт



Д/Д	ХААБ-ИЙН НЭРС
1	"ИВЭЭЛТ-ИНЭЛ ХААБ" ХХК
2	"РОЯЛ КАШИМЕР ХААБ" ХХК
3	"ТАНАНДЭЭЖ ТРЭЙД ХААБ" ХХК
4	"УВС ТАВАН ЭРДЭНИЙН УНДАРГА ХААБ" ХХК